

ГОЛОМТ БАНК ХК

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар
2023 он**

1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2 – оос доошгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

| № | Гарчиг | Авбал зохих нийт оноо | Үнэлсэн оноо | Хяналтын оноо | Үнэлгээний хувь |
|---|---|-----------------------|--------------|---------------|-----------------|
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 12 | | 100% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 10 | | 100% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод байдал | 6 | 6 | | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 6 | | 100% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | | 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 6 | | 100% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | | 100% |
| 8 | Компанийн соёл | 6 | 6 | | 100% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 10 | | 100% |
| | Нэгдсэн дүн | 72 | 72 | | 100% |

3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

- 3.2.2.70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3.50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4.49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

4. Үнэлгээний асуулга

“Голомт банк” ХК

/нэр/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

| № | Зүйл | Хэрэгжилт | Тайлбар | Оноо | Хувь |
|---|---|--------------------|---|------|------|
| 1 | <i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь хамгийн анх 2010 оны 05 сарын 06-ны өдрийн 10/03 тоот Тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлан, түүнээс хойш шаардлагатай үед шинэчилж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлсээр ирсэн байна. Тус журамд ТУЗ-ийн дарга, гишүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулсан. Мөн ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтын хүрээнд ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын чиг үүргийг тодорхойлж зохицуулсан ба ТУЗ-өөр ТУЗ-ийн НБД-ийн АБТ-ыг баталсан байна. ХК болж байгаатай холбоотойгоор Голомт банк нь үндсэн Засаглалын код, ХЭХ болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хороодын дүрмээ сайжруулах шинэчлэхээр төлөвлөж ажиллаж байна. | 2 | |
| 2 | <i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны ТУЗ нь дэргэдээ 3 хороодтой үйл ажиллагаа явуулдаг. Үүний нэг нь "Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх" хороо юм. Тус хорооны журамд ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон газрын захирлын албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тогтооход ТУЗ-д туслах, холбогдох зөвлөмжийг боловсруулах талаар тусгасан. Мөн тус хорооноос банкны Хүний нөөцийн бодлогыг ГУ-тай хамтран боловруулж ТУЗ-өөс батлахад зөвлөмж гаргаж ажилладаг ба тус бодлогод банкны Залгамж болон удирдах ажилтныг тасралтгүй бэлтгэх, ажилтны сургалт хөгжил, карьерийн замнал зэрэг асуудлыг тусгасан байна. Энэхүү бодлогыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг ГУ-д өгсөн ба тус ХН бодлогыг хамгийн сүүлд 2022 оны 03 сарын 24ны ТУЗ-ийн 00/12 тоот Тогтоолоор шинэчлэн баталсан байна. | 2 | |

| | | | | | |
|---|---|--------------------|---|---|--|
| 3 | <p>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</p> | Бүрэн хэрэгжүүлсэн | <p>www.golomtbank.com цахим хуудас болон 2021 оны Жилийн үйл ажиллагааны тайланд Голомт банкны ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдлын мэдээллийг тусгасан. Мөн тайлант хугацаанд ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа, хурлын давтамж зэрэг мэдээллүүд багтсан байна. Мөн банкны зохицуулалтын хүрээнд ТУЗ болон ХЭХ-ийн хурлын ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэрлэсэн байдал зэргийг дэлгэрэнгүй байдлаар зохицуулагч байгууллагад тухай бүр мэдээлж, мөн жилийн үйл ажиллагаа, засаглалын тайланд бүрэн тайлагнаж мэдээллийг хүргүүлж ажилласан байна. ХК болж байгаатай холбоотойгоор гишүүдийн ТУЗ-ийн хурал болон хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ирц, ТУЗ-ийн ажлын тайланг жилийн тайланд мэдээлж, цахим хуудсаар дамжуулан нийтлэх техникийн болон агуулгын шийдлүүдийг гаргаж, гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> | 2 | |
| 4 | <p>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</p> | Бүрэн хэрэгжүүлсэн | <p>Голомт банкны ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодууд журам дүрэмтэй, Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэмд бүтэц бүрэлдэхүүн, гишүүний ур чадварын талаар тусгасан. Аудитын хорооны дүрэмд бүтэц, зохион байгуулалтын талаар тусгасан. Мөн хууль журмын дагуу ТУЗ-ийн Хараат бус гишүүн тус Аудит болон Эрсдэлийн удирдлагын хороодын Даргалдаг ба хороо тус бүр хариуцсан үүрэг хариуцлагынхаа хүрээнд шийдвэр гаргаж, ТУЗ-д зөвлөмж өгч, ГҮ-д үүрэг өгч хэрэгжилтийг хянаж ажилладаг. Мөн ТУЗ-ийн хурлаар үйл ажиллагааны тайлангаа тогтмол тайлагнаж ажилладаг. Тус хороодод хамгийн чухал тавигдаг шаардлага болох Хараат бус гишүүдийн оролцоог бүрэн хангасан ба ТУЗ-ийн нийт Хараат бус гишүүд 3-уулаа Аудит, ЭУХороонд гишүүнээр ажилладаг ба ТУЗ-ийн нийт буюу 2 эмэгтэй гишүүд хороодын гишүүнээр ажиллаж байна. ТУЗ-ийн Хороодын бүрэлдэхүүн golomtbank.com цахим хуудаснаа нээлттэй байршиж байна.</p> | 2 | |
| 5 | <p>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</p> | Бүрэн хэрэгжүүлсэн | <p>Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд нь чиглүүлэх хөтөлбөрт хамрагддаг бөгөөд ХЭХ-аас шинэ сонгогдсон даруйд нь уг сургалтыг боломжтой үед нь зохион байгуулдаг. Уг сургалтын хөтөлбөр нь тухайн гишүүний мэргэжлийн ур чадвар, хэрэгцээнд нь тулгуурласан байна. Уг хөтөлбөр нь бусад асуудлаас гадна дараах асуудлыг заавал хамрах бөгөөд үүнд Банкны хууль, удирдлагын бүтэц, банкны дүрэм, засаглалын кодекс, банкны үйл ажиллагааны зохицуулалтууд, банкны</p> | 2 | |

| | | | | | |
|---|---|--------------------|--|-----------|-------------|
| | | | үндсэн бодлого журмууд, ёс зүйн дүрэм, банкны зорилго, стратегийн бизнес төлөвлөгөө, банкны санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгийн удирдлага, банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа багтдаг. Хөтөлбөрийн хүрээнд мөн шаардлагатай мэдээллийг хүргэх гол ГУ-ийн багийн гишүүдтэй уулзуулж өнгөрсөн болон ирээдүйд хийгдсэн ажлууд, төлөвлөгдөж байгаа зүйлсийн талаар мэдээллийг хүргүүлдэг ба үндсэн салбарын үйл ажиллагааг танилцуулах газар дээрх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн. Мөн ТУЗ-ийн гишүүдийн зүгээс гишүүдийг өөрсдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сургалтад хамрагдах явдлыг дэмжиж ажилладаг бөгөөд ТУЗ-ийн урьдчилсан зөвшөөрлийн үндсэн дээр уг сургалт болон зардлыг банкнаас хариуцаж ажилладаг. | | |
| 6 | <i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны дүрэмд хуулийн дагуу ТУЗ-ийн НБД-ыг Эрх бүхий албан тушаалтан хэмээн тунхаглаж хариуцлагажуулсан байдаг. ТУЗ-ийн Даргын санал болгосны дагуу ТУЗ нь НБД-ыг томилсон. 2020 оны 05 сарын ТУЗ-ийн Засаглал, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороогоор ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын тайлан мэдээлэлтэй танилцаж, контрактын гэрээг байгуулах шийдвэр гаргаж байсны дагуу Контрактын гэрээнд ТУЗ-өөс үүрэг хариуцлагыг тодорхой зохицуулан тусгасан байна. | 2 | |
| ДҮН | | | | 12 | 100% |
| ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ | | | | | |
| ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ | | | | | |
| 7 | <i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Хуулийн дагуу системийн нөлөө бүхий банк Голомт банкны ТУЗ нь нийт 9 гишүүнтэй бөгөөд нийт гишүүдийн 3/1 буюу 3 хараат бус гишүүнтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Мөнхцэцэг нь ердийн гишүүн юм. Харин ТУЗ-ийн Аудит болон Эрсдэлийн удирдлагын хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн ба тус хороодын дийлэнх гишүүдийг Хараат бус гишүүдээр бүрдүүлсэн байна. Тухайлбал Аудитын, ЭУХорооны дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн (Хорооны Дарга мөн адил) ба үлдсэн гишүүд буюу 2 гишүүн нь ТУЗ-ийн ердийн гишүүн байна. Тэр дотор Аудитын хорооны гишүүн ТУЗ-ийн ердийн 1 гишүүн нь жижиг хувьцаа эзэмшигч Ажилтнуудыг төлөөлөн ТУЗ-д суудаг гишүүн болно. | 2 | |
| 8 | <i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүрэм 2021 оны 5 сарын 28-нд шинэчлэгдэн батлагдсан. Аудитын хорооны даргаар төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн ноён | 2 | |

| | | | | | |
|---|---|------------------------|---|----|------|
| | <i>Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i> | | Жэймс Б.Двайер ажилладаг бөгөөд ноён Жэймс Б.Двайер нь Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга биш юм. Аудитын хорооны гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байдаг. Аудитын хорооны дүрмийн 4.1.1-т зааснаар Аудитын хороо нь дараах эрхтэй. 4.1.1 Хорооны эрхлэх асуудлын хүрээнд ирүүлсэн тайлан, мэдээллийг хянах, холбогдох албан тушаалтныг хуралд оролцуулах, аман болон бичгэн хэлбэрээр тайлбар, тодруулга авах | | |
| 9 | <i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i> | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь банкны хууль дүрмийн зохицуулалтын хүрээнд ТУЗ-ийн Хороод оо зохион байгуулсан байна. "Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх" хорооны үйл ажиллагааг зохицуулсан дүрэмтэй ба тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг ажилладаг. ХК болж буйтай холбоотой ЗЁЦУНДХорооны нэгдсэн чиг үүргийг төрөлжүүлж салгах, зохион байгуулалтыг өөрчлөх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнтэй холбоотой Нэр дэвшүүлэх хороог тусад нь гаргаж, Гишүүдийн бүрэлдэхүүн Даргыг дахин хэлэлцэн томилсон ба дийлэнх гишүүд ТУЗ-ийн Хараат бус гишүүд ба Хорооны Дарга мөн ТУЗ-ийн Хараат бус гишүүн томилогдсон байна. | 2 | |
| 10 | <i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i> | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь банкны хууль дүрмийн зохицуулалтын хүрээнд ТУЗ-ийн Хороод оо зохион байгуулсан байна. "Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх" хорооны үйл ажиллагааг зохицуулсан дүрэмтэй ба тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг ажилладаг. ХК болж буйтай холбоотой ЗЁЦУНДХорооны нэгдсэн чиг үүргийг төрөлжүүлж салгах, зохион байгуулалтыг өөрчлөх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнтэй холбоотой Нэр дэвшүүлэх хороог тусад нь гаргаж, Гишүүдийн бүрэлдэхүүн Даргыг дахин хэлэлцэн томилохоор ажиллаж байна. | 2 | |
| 11 | <i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны ТУЗ нь дэргэдээ нийт 3 хороодтой. Үүнд: "Эрсдэлийн удирдлагын хороо", "Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо", "Аудитын хороо багтаж байна". Хороод бүгд үйл ажиллагааны дүрэм, журам заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй. | 2 | |
| ДҮН | | | | 10 | 100% |
| ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ | | | | | |

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

| | | | | | |
|----|---|--------------------|--|---|--|
| 12 | 3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны Засаглалын кодексын Аудит ба тайлагнал бүлэгт нийтэд хүргэх мэдээллийн жагсаалтыг баталсан. Тайлант хугацаанд хамаарах зохицуулагчийн Зохистой засаглалын журмын дагуу санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг ил болгодог ба Голомт банкны Мэдээллийг бодлого, Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, ГБ нягтлан бодох бүртгэлийн бодлого, мэдээллийн ангилал, нууцыг хамгаалах, зохистой хэрэглээний журмуудын дагуу мэдээллүүдийг тодорхойлж нийтэд ил тод болгох мэдээллийг хууль журмын дагуу цахим хуудас, жилийн тайлан, зохицуулагчид тус тус тогтмол тайлагнаж, хянадаг. | 2 | |
| 13 | 3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ. | Хэрэгжсэн | Компанийн засаглалын баримт бичиг, дүрэм, журмыг цахим хуудсаараа дамжуулан нийтэлсэн. 2022.12.31-ний байдлаар Голомт банкны www.golomtbank.com цахим хуудаст: Хувьцаа эзэмшлийн бүтэц, ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба товч намтар, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайлан ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, Удирдлагын баг, Компанийн бүтэц, Компанийн засаглалын бүтэц, Комплаенс, Дотоод хяналтын талаар мэдээлэл, Санхүүгийн тайлан жилээр, улирлаар, Жилийн үйл ажиллагааны тайлан, Тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл, Тогтвортой хөгжлийн тайлан зэрэг мэдээллүүд монгол болон англи хэл дээр нийтлэгдсэн. Цаашид бид цахим хуудсаа улам хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах, зохицуулагч байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд тавьж буй шаардлагыг биелүүлж ажиллахаар төлөвлөж байна. | 2 | |
| 14 | 3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна. | Бүрэн хэрэгжүүлсэн | 2021 оны Голомт банкны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт хангалттай цэвэр гарсан ба ямар нэгэн санхүүгийн хүндрэлтэй байдалд орж болзошгүй зүйл байхгүй болно. Санхүүгийн бус тайлагналын хүрээнд 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланд эдийн засгийн орчин, хөрөнгийн зах зээл, жижиг дунд бизнесийн салбар, олон улсын бизнес харилцаа, тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлага, эрсдэлийн удирдлага, комплаенсын талаарх тайлан, мэдээ, мэдээллийг оруулсан. Мөн тогтвортой хөгжлийн тайланг тусад нь бэлтгэн нийтэлсэн. Голомт банк нь Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийн лимитүүдийг баталдаг ба эдгээрт санхүүгийн, санхүүгийн бус үйл ажиллагааны зэрэг бүх төрлийн | 2 | |

| | | | | | |
|---|--|---|---|-------------|--|
| | | үзүүлэлтүүд багтдаг. Эдгээрийг тухай бүр стратегитай уялдуулан шинэчлэн баталдаг ба баталсан лимитүүдийн хэрэгжилтийг улирал бүр ТУЗ-д тогтмол тайлагнадаг болно. | | | |
| ДҮН | | | 6 | 100% | |
| ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО | | | | | |
| ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана | | | | | |
| 15 | <p>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p> | <p>Бүрэн хэрэгжүүлсэн</p> | <p>Аудитын хорооны дүрмийн 4.2.26-4.2.38-д хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг тусгасан байдаг.</p> <p>4.2.26 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хараат бус байдлыг хангах тухай журам гаргаж, мөрдөх</p> <p>4.2.27 Хөндлөнгийн аудитын байгууллагын ажлын саналд тусгагдсан аудитын хамрах хүрээг батлах, арга аргачлалыг хянах,</p> <p>4.2.28 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, чөлөөлөх болон төлбөрийн тухай саналыг ТУЗ-д гаргах,</p> <p>4.2.29 Хөндлөнгийн аудитын байгууллагаас үзүүлэх аудитын бус үйлчилгээтэй холбоотой тайлан мэдээг сонсох, аудитын бус үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргах,</p> <p>4.2.30 Хөндлөнгийн аудитын байгууллагын ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх,</p> <p>4.2.31 Хөндлөнгийн аудитын байгууллагыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нөөц, нөхцөл бололцоогоор хангах,</p> <p>4.2.32 Хараат бус байдал нь алдагдах эрсдэл бий эсэх талаар хөндлөнгийн аудитын байгууллагатай жил бүр хэлэлцэх,</p> <p>4.2.33 Хөндлөнгийн аудитын байгууллагын баталгаажуулсан санхүүгийн тайлан болон аудит хийх үед үүссэн аливаа хүндрэлийг хэлэлцэж, аудитын тайлан, санал зөвлөмжийг ТУЗ-д танилцуулах,</p> <p>4.2.34 Тогтмол хугацаанд хөндлөнгийн аудиторуудтай уулзаж, хороо болон хөндлөнгийн аудиторууд Удирдлагын багаас тусдаа хэлэлцэх асуудал бий эсэхийг нягтлах, уулзалтад Аудит хариуцсан захирлыг оролцуулах,</p> <p>4.2.35 Санхүүгийн тайлагналтай холбоотой Удирдлага болон хөндлөнгийн аудиторын маргааныг эцэслэн шийдэх</p> <p>4.2.36 Хөндлөнгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих,</p> <p>4.2.37 Банк нь баримт, материалуудыг хадгалахдаа баримт хадгалах журмыг мөрдөж буй эсэхэд хяналт тавих,</p> <p>4.2.38 Олон улсад мөрдөгдөж буй, шинээр гарч буй аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаар тогтмол мэдээлэлтэй байх.</p> | 2 | |

| | | | | | |
|---|--|--------------------|--|----------|-------------|
| 16 | 4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна. | Бүрэн хэрэгжүүлсэн | 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд (04 сарын 26-ны өдөр) хөндлөнгийн аудиторыг оролцуулж, аудитын үр дүнг Хувьцаа эзэмшигчдэд хөндлөнгийн аудитаас танилцуулснаас гадна, асуултад хариулахад бэлэн байж хуралд оролцсон болно. 2022 оны Голомт банкны Санхүүгийн үр дүн нь Аудитын хороонд танилцуулагдан, хорооны зөвлөмжөөр ТУЗ-д танилцуулагдаж 2023.03.29-ны өдрдийн хурлаар батлагдсан ба ТУЗ-өөс ХЭХ-д батлах зөвлөмж гаргаж ХЭХ-ийн 2023.04.26-ны хурлаар 2022 оны үйл ажиллагаа санхүүгийн үр дүнд өгсөн ТУЗ-ийн үнэлгээг баталсан болно. 2022 оны Санхүүгийн үр дүн Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтээр хангалттай, цэвэр гарсан бөгөөд бүх төрлийн баримт нотолгоогоор батлагдсан болно. | 2 | |
| 17 | 4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ. | Бүрэн хэрэгжүүлсэн | Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг Банкны жилийн тайлан дээр жил бүр тусгахаас гадна эдгээр мэдээллийг цахим хуудаст байнга байршуулан, өөрчлөлт орох бүрт шинэчилж байна. | 2 | |
| ДҮН | | | | 6 | 100% |
| ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина | | | | | |
| 18 | 5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт Банк ХК-ийн Эрсдэлийн удирдлагын газар нь 2007 оны 09 сард байгуулагдаж, газрын үйл ажиллагааны анхны дүрэм 2007 оны 9-р сарын 10-ны өдрийн 378 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан ба сүүлийн байдлаар 2020 оны 8-р сарын 21-ний 323 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэгдэн батлагдсан. Эрсдэлийн удирдлагын газар нь Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Эрсдэл хариуцсан захирлын харьяаны нэгж бөгөөд 4 хэлтэстэйгээр банкны эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Голомт банк нь ТУЗ-өөс баталсан Эрсдэлийн удирдлагын тогтолцооны эрсдэлийн 3 шугамын аргачлалын дагуу банкны бүхий л төрлийн эрсдэлүүдийг удирдан ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын газар нь Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороогоор дамжуулан ТУЗ-д банкны эрсдэлүүдийг тайлагнаж, эрсдэлийн хязгаарлалтуудыг батлуулдаг. Зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал, МУТСТ, | 2 | |

| | | | | | |
|----|--|--------------------|---|---|--|
| | | | хянан нийцүүлэх, эдийн засгийн зэрэг эрсдэлүүдийн хүрээнд Эрсдэлийн удирдлагын тайланг бэлтгэн жилд дор хаяж 4 удаа Эрсдэлийн удирдлагын хороог хуралдуулж байна. Түүнчлэн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороогоор гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын хэмжээнд банкны Эрсдэлийн удирдлагын хороо сар бүр хуралдаж эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байна. | | |
| 19 | 5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны ТУЗ нь дэргэдээ Эрсдэлийн удирдлагын хороотой ба нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. Хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б.Двайер ажилладаг. Хорооны бүрэлдэхүүний хувьд дийлэнх буюу 3 гишүүн хараат бус гишүүд байдаг. Тус хорооны чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, тухайн тайлант жилд хэлэлцсэн асуудлууд, хуралдсан хурлын тоо, баталсан баримт бичгүүдийн талаар товч тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан-компанийн засаглал хэсэг болон цахим хуудсаар тогтмол тайлагнадаг. Хорооны дэлгэрэнгүй тайланд хууль журмын хүрээнд зохицуулагчруу тогтмол хүргүүлдэг. Мөн Голомт банкны цахим хуудаснаа ТУЗ-ийн Хараат бус гишүүний тайланг улирал бүр тогтмол нийтэлдэг ба тус тайланд хороодын хурлын давтамж, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр зэрэг мэдээллүүд багтдаг. | 2 | |
| 20 | 5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банк 2019 оны 9-р сарын 22-ны өдөр АНУ-ын Нью Йорк хотноо “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч банкнуудын нэг болж, өөрийн үйл ажиллагааг “Тогтвортой хөгжлийн зорилтууд” болон “Парисын гэрээний уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтууд”-тай уялдуулан ажиллахаа тунхагласан. Үүнтэй холбоотойгоор Гүйцэтгэх захирлын 2019 оны 10-р сарын 11-ний өдрийн 434 тоот тушаалаар "Тогтвортой хөгжлийн бодлого", 2022 оны 11-р сарын 02-ны өдрийн 1246 тоот тушаалаар "Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх дотоод журам"-ыг тус тус шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Түүчлэн жил бүр "Тогтвортой хөгжлийн тайлан"-г боловсруулан, өөрийн вебсайтаар дамжуулан олон нийтэд мэдээллэж байна. | 2 | |
| 21 | 5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь Комплаенсийн хэлтсийг 2016 оны 3 сард байгуулсан бөгөөд тус хэлтэс нь Ерөнхийлөгчийн харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг. Хэлтэс нь үйл ажиллагаандаа ТУЗ-ийн 2022 оны 6-р сарын 21-ний өдрийн 00/21 тоот тогтоолоор батлагдсан Комплаенсийн бодлогыг мөрдөж ажилладаг бөгөөд банкинд | 2 | |

хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй. Комплаенсийн хэлтсээс улирал бүр ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороонд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа болон Комплаенсийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хараат бусаар тайлагнадаг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ нэгж нь Ерөнхийлөгчийн удирдлаганд нийт 9 орон тоотойгоор ажиллаж байна. Хэлтсийн захирал Ц.Чаминчимэг нь 2019.11 сард Комплаенсийн хэлтэсд томилогдсон ба банканд 2001 оноос хойш салбар нэгжид теллер, гадаад төлбөр тооцоо, SWIFT-н алба болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээр тус тус ажилласан туршлагатай болно. МУТСТ ахлах мэргэжилтэн Н.Мөнхжаргал нь МУТСТ чиглэлээр 18 жил ажилласан туршлагатай ба 2011 онд Люксембург хотноо CAMS шалгалтыг амжилттай өгч тус цолыг хүртсэн ба 2019 онд дахин амжилттай баталгаажуулсан.

ТУЗ-н Эрсдэлийн удирдлагын хороо нь улирал тутам Комплаенсийн/МУТСТ/ үйл ажиллагааны явц, нөхцөл байдал, эрсдэл, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээ авахыг үүрэг болгон, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг болно.

Банкны Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аргаар банкны нэгжүүдийг хянан шалгадаг ба эрсдэл бүхий нэгжүүдийг жилд 1 удаа шалгах бодлого баримтлан хэрэгжүүлж ТУЗ-н дэргэдэх Аудитын хороогоор гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж ажилладаг. Голомт банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (цаашид “МУТС” гэх)-тэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь дараах баримт бичгээр заагдсан тогтолцооны дагуу хэрэгжиж байна. Үүнд:

1. Банкны ТУЗ-өөс баталж, мөрдүүлж буй зохицуулалтууд:
 - 1.1. “Эрсдэлийн Удирдлагын Тогтолцоо / Эрсдэлийн Аппетитийн Тунхаглал” бодлогын баримт бичиг;
 - 1.2. “Эрсдэлийн Аппетитийн Мэдэгдэл” – Эрсдэлийн лимит хязгаарлалтууд;
 - 1.3. “Эрсдэлийн таксономи” – Эрсдэлийн ангилал, хариуцсан хамгаалалтын бүсүүд;
 - 1.4. “Голомт банкны Комплаенсийн Бодлого”;
 - 1.5. “Голомт банкны ёс зүйн кодексе”;
 - 1.6. “Эрсдэлийн удирдлагын бодлого”;
2. Гүйцэтгэх удирдлага болон Комплаенс хариуцсан нэгжийн зүгээс баталж, мөрдүүлж буй зохицуулалтууд:
 - 2.1. “МУТСТ үйл ажиллагааны журам”;

2.2. “МУТСТ сэжигтэй гүйлгээг хянах, СМА-д мэдээллэх үйл ажиллагааны стандарт, түүнийг хэрэгжүүлэх заавар”;

2.3. МУТСТ эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гарын авлага;

2.4. “Эцсийн өмчлөгчийг тодорхойлох гарын авлага”;

2.5. УТНБЭ-ийг тодорхойлох, хянах мэдээлэх заавар;

2.6. “Харилцагч таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх гарын авлага”;

2.7. “Харилцагчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх заавар”;

2.8. “Корреспондент банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх заавар”;

2.9. “Бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг хүргэх арга хэлбэрийн комплаенсийн эрсдэлийг үнэлэх заавар”;

2.10. "МУТСЭрсдэлийн нэгдсэн үнэлгээний түр аргачлал";

2.11. (2.1)-н хүрээнд банкны харилцагч бүртгэх, бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх болон бусад дотоод процесс үйл ажиллагааны зохицуулалтын журам, стандарт, заавар, гарын авлагууд;

Дээрх журам зааврыг бүрэн хэрэгжүүлэх зорилгын хүрээнд холбогдох нэгжүүд шат шатны сургалт хийхийн хамт, дижитал сургалтын материал бэлдэх, сургалт болгоны дараа холбогдох шалгалтуудыг авч үр дүнг ХНУГ-аас тодорхойлон ажилладаг болно.

Мөн Комплаенсийн хэлтсээс хагас жил бүр мэдлэг шалгах түвшин тогтоох шалгалт авдаг ба жил ирэх бүр шалгалтын цар хүрээ, тест авах аргачлал зэргийг сайжруулан ажиллаж байна.

ТУЗ нь улирал бүр МУТСТ үйл ажиллагааны тайлантай дэлгэрэнгүй танилцаж, банкны МУТСТ үйл ажиллагаанд чухал ач холбогдол өгөн шаардлагатай чиглэл үүрэг, зохистой шийдвэрийг тухай бүр гарган ажиллаж байна. Мөн эрсдэлийн үнэлгээний тайланг хэлэлцэж, үнэлгээний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу үүрэг өгч, түүний хэрэгжилтийг хянаж ажилладаг.

Мөн банкны Комплаенсийн хэлтэс нь эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах үндсэн чиглэлээр тасралтгүй сайжруулалтыг хийн ажиллаж байна. Үүнд:

- Банкны нийт МУТС эрсдэлийн нэгдсэн үнэлгээний түр аргачлалыг дэлхийн банкны стандартын дагуу боловсруулан батлуулан, эрсдэлийн үнэлгээг хийв;
- Корреспондент банк, бусад санхүүгийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийх;

| | | | | | |
|--|---|--------------------|--|----------|-------------|
| | | | <input type="checkbox"/> Банкны бүтээгдэхүүн үйлчилгээнд онцлон МУТСТ эрсдэлийн дүгнэлт гаргах; <input type="checkbox"/> Шинээр зах зээлд гаргаж байгаа эсхүл өөрчлөлт орж буй бүтээгдэхүүн үйлчилгээнд эрсдэлийн дүгнэлт гаргах; <input type="checkbox"/> Нийт харилцагчид МУТСТ эрсдэлийн үнэлгээ хийх системийн тохиргоо, өгөгдлийн чанарыг удирдах; <input type="checkbox"/> Шаардлагатай ахисан түвшний судалгаа, гүйлгээний хяналтыг тогтмол хэрэгжүүлэх гэх мэт; | | |
| ДҮН | | | | 8 | 100% |
| ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ | | | | | |
| Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна | | | | | |
| 22 | 6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны 2022 оны 03 сард болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгохдоо Гишүүн тус бүрийн цалин урамшууллыг ил тод хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Голомт банк нь 2022 оны 11 сард албан ёсоор Хөрөнгийн бирж дээр бүртгэгдлээ. 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2023 оны 04 сард зарлан хуралдуулах ба тус хурлаар дахин ТУЗ-ийн гишүүдийн томилгоог хэлэлцэн батлах төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 2 | |
| 23 | 6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана. | Бүрэн хэрэгжүүлсэн | <p>Голомт банкны цалин хөлс нь банкны стратеги, хүний нөөцийн бодлоготой уялдаатай байдаг. Гүйцэтгэх захирлын 2022 оны 959 тоот тушаалаар "Цалин хөлсний журам"-ыг шинэчлэн баталсан.</p> <p>Ажилтнуудын цалин нь албан тушаалын түвшин, албан тушаалын зэрэглэл, гүйцэтгэж буй ажлын цар хүрээ, ажилтны ур чадвар, гүйцэтгэлийн үнэлгээ зэргээс хамааран ялгаатай байдаг. Банкны цалин хөлсний систем нь шударга, үл ялгаварлах, нууцлалтай, нэгдмэл нэг системтэй, хуульд нийцсэн зарчмуудыг баримталдаг.</p> <p>2. Голомт банкны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ нь төвийн нэгжийн, салбар тооцооны төвийн, ажилтнуудын гэсэн нийт 3 түвшинтэй. Үүний хүрээнд Гүйцэтгэх захирлын 2022 оны 1025 тоот, 1116 тушаалаар тус тус "Төвийн нэгж болон Салбар тооцооны төвийн гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын дагуу ТУЗ-аас баталсан бизнес төлөвлөгөө, зорилго, стратегитай уялдуулан нэгжүүдийн зорилго, зорилт, КРІ үзүүлэлтүүд батлагддаг. Энэхүү журмын дагуу хагас жилд нэг удаа, Банкны гүйцэтгэл 85%-иас дээш, нэгжийн гүйцэтгэл 75%-иас, ажилтны гүйцэтгэл 80%-иас дээш тохиолдолд урамшуулал олгодог.</p> | 2 | |
| 24 | 6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх | Хэрэгжүүлсэн | Тайлант хугацаанд Голомт банкны зохицуулалтийн хүрээнд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал, бусад | 2 | |

| | | | | | |
|--|--|--------------------|--|----------|-------------|
| | <i>удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i> | | урамшууллыг, олгох гүйцэтгэлийн шалгуурыг ГЗ-ийн хамт ТУЗ-өөс баталж, гүйцэтгэлийг хянаж ажилласан. Энэ тухайгаа зохицуулагч байгууллага, шат дараалсан эрх бүхий этгээдүүдэд нээлттэй тайлагнаж, хууль журмын шаардлагыг хангаж ажилласан байна. Голомт банкны жилийн тайланд цалин урамшууллын баримтлах бодлогыг ерөнхийлөн тусгаж ажилласан. Нээлттэй хувьцаат компани болж буй үйл ажиллагааны хүрээнд Голомт банкны цахим хуудаснаа Засаглалын ил тод мэдээллийн хэсгийг хөгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байгаа ба энэхүү хэсэгт мэдээллийг багтаан ажиллах болно. | | |
| ДҮН | | | | 6 | 100% |
| ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ | | | | | |
| Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ | | | | | |
| 25 | <i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны дүрэм, банкны засаглалын кодекс-д компанийн оролцогч талуудын харилцааг тусгаж, зохицуулалт оруулсан байдаг. Мөн зохицуулагчийн зохистой засаглалыг хэрэгжүүлэх хууль дүрмийн дагуу тайгнал болон томилгоог гүйцэтгэж ажилладаг. ХЭХ, ТУЗ, ГУ-ийн бүрэн эрх, шийдвэр гаргах хэм хэмжээг банкны дүрэм, засаглалын код болон бусад дагалдах дүрэм журмуудад тусгасан байна. Мөн шийдвэр гаргах эрхийн матрицийг ерөнхий шийдвэр талаар хууль комплаенсийн хэлтсүүд гаргаж мөрдөхөд дэмжиж ажилладаг, зээл талаас ТУЗ-ийн баталсан зээлийн бодлого, зээлийн хорооны дүрмийн хавралтаар баталж байдаг. Эдгээрийн хэрэгжилтийг хянаж тухай бүр холбогдох тайлангуудыг хүргүүлж, хэлэлцэн ажиллаж байна. | 2 | |
| 26 | <i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны жилийн тайланд Голомт банкны баримталсан үндсэн стратеги, ХЭ-ийн бүтэц бүрэлдэхүүн, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан бодлого, тайлант хугацаанд баримталсан стратеги, анхаарсан асуудал, гаргасан шийдвэрүүдийн тухай тайлагнадаг. Мөн төлөвлөгөөг хэрхэн биелүүлсэн, тухай бүр өгсөн үүрэг зөвлөмжийн биелэлт, ерөнхий үйл ажиллагааны үнэлгээ, ГУ-ийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийж ажилладаг. | 2 | |
| 27 | <i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл, Банк эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, Дотоод хяналтын тогтолцоо, Засаглалын тогтолцоо, Санхүүгийн тайлангийн тайлагнал, Хэлцэлийн талаар толилуулах Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээлэх, Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд зэрэг мэдээллийг банкны үндсэн вебсайтад олон нийтэд нээлттэй байдлаар байршуулсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдол тухай бүрд шинэчилдэг. | 2 | |

| | | | | | |
|---|--|---------------------------|--|-------------|--|
| 28 | <p>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</p> | <p>Бүрэн хэрэгжүүлсэн</p> | <p>Голомт банк нь дараах баримт бичгүүдээр батлагдсан зохицуулалтын хүрээнд дотоод зөрчлийн асуудлуудыг хүлээн авч, шийдвэрлэж ажилладаг. Эдгээр зохицуулалтуудыг хамруулсан банкны шинэ ажилтанд болон нийт ажилтнуудад зориулсан сургалт, мэдлэг бататгах шалгалтууд тодорхой давтамжтай зохион байгуулагддаг.</p> <p>1. Голомт банкны ТУЗ-ийн 2014.03.28-ны өдрийн 00/08 тоот тогтоолоор батлагдсан “Голомт банкны засаглалын кодекс”-н “Зөрчлийн тухай мэдээлэх бодлого” бүлэг; - Хавсралт 1</p> <p>2. Голомт банкны ТУЗ-ийн 2022.06.21-ны өдрийн 00/21 тоот тогтоолоор батлагдсан “Голомт банкны Комплаенсийн бодлого”-ын (2.6)-р заалт; - Хавсралт 2</p> <p>3. Комплаенсийн хэлтсээс Банкны нийт нэгж, ажилтнуудад зориулан гаргасан “Зөрчлийг мэдээлэх заавар” – Хавсралт 3</p> <p>Мөн ажилтан санал хүсэлт, гомдлоо нэгжийн удирдлага болон ХНУГ-т хүргэдэг. Энэхүү процесс нь дээрх баримт бичгүүдээр зохицуулагдахаас гадна салбар тооцооны төв болон төвийн нэгжийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журам, цалин хөлсний журамд тус тус тусгагдсан байдаг.</p> <p>Гүйцэтгэх захирлын 2021 оны 502 тоот тушаалаар Ажилтанд нийгэм ахуйн хөнгөлөлт үзүүлэх, тэтгэмж олгох журмын шинэчлэн баталсан ба банкны нийт ажилтнуудын нийгэм, ахуйн асуудлуудыг шийдвэрлэдэг.</p> <p>Гүйцэтгэх захирлын 2022 оны 1006 тоот тушаалаар Сургалт хөгжлийн журам шинэчлэн батлагдсан ба ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлагыг тасралтгүй сайжруулах, хөгжүүлэх зорилгоор банкны сургалт хөгжлийн хэрэгцээ тодорхойлох, сургалт хөгжлийн хөтөлбөр зохион байгуулах, сургалтыг үнэлэх болон бусад харилцааг зохицуулдаг. Банкны ур чадварын матрицтай уялдуулсан сургалт хөгжлийн моделийн дагуу ажилтнууд бэлтгэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагддаг.</p> | 2 | |
| ДҮН | | | 8 | 100% | |
| НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно | | | | | |
| 29 | <p>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн</p> | <p>Бүрэн хэрэгжүүлсэн</p> | <p>Голомт банкны алсын хараа - Дэлхийн жишиг Монголын банк. Эрхэм зорилго - Хөгжлийн голомт. Уриа - Сайн сайхныг санхүүжүүлнэ. Үнэт зүйлс: Шударга зарчимч байх, Бууж өгөхгүй байх, Хариуцлагатай байх, Хамтач сэтгэлгээтэй байх, Хайрцагнаас гарч сэтгэ, Хувь нэмрээ</p> | 2 | |

| | | | | | |
|---|---|--------------------|--|----------|-------------|
| | <i>дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i> | | оруул, Чин хүсэлт эрмэлзэлтэй байх, Харилцагч төвтэй байх. Голомт банкны ТУЗ нь Ёс зүйн кодыг баталсан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Засаглалын код нь Голомт банкны засаглалын тунхаг бичиг баримт ба түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэгт банкны ёс зүйн код багтдаг. Энэхүү мэдээллийг бид оролцогч талууд, хамтран ажиллагсадад ил тодоор мэдээллэж засаглалын зарчмыг танилцуулдаг. | | |
| 30 | <i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь "Шүгэл үлээх тогтолцоо"-той бөгөөд и-мейл, утас, хайрцаг, биечлэн уулзах зэрэг 4 төрлийн сувгуудаар хүлээн авч байна. Шүгэл үлээх сувгаар ирүүлсэн мэдээлэлд баталгаажуулалт хийхдээ мэдээлэгчийн нууцлалыг маш сайн хадгалдаг. Шүгэл үлээх сувгаар ирсэн мэдээллийг тусгай санд бүртгэдэг бөгөөд тус санд Аудитын хорооны дарга, Аудит хариуцсан захирал, Комплаенсийн хэлтсийн захирал хандах жрхтэй байдаг. Мэдээллийн дагуу хийгдсэн баталгаажуулалтын талаарх мэдээллийг улирал бүр Дотоод аудитын үйл ажиллагааны тайланд тусгадаг ба Аудитын хороонд тайлагнадаг. | 2 | |
| 31 | <i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны Засаглалын кодекс нь дараах бүлгүүдээс бүрдэнэ. 1. Голомт банкны засаглалын бүтэц 2. Голомт банкны ёс зүйн код 3. Голомт банкны авлигын эсрэг бодлого 4. Сонирхлын зөрчилтэй асуудал шийдвэрлэх журам 5. Мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого 6. Луйврын эсрэг бодлого 7. Улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого 8. Зөрчлийн тухай мэдээлэх бодлого Эдгээр бодлого, журмуудын дагуу Банкны ажилтнуудад хээл хахууль, авилга өгөх, хүлээн авах, түүнд оролцохыг хориглодог. Мөн Голомт банк нь аливаа улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй байх ерөнхий бодлогыг баримтлахаас гадна Голомт банкнаас болон Голомт банкны нэрийн өмнөөс улс төрийн нам, эвсэлд аливаа хэлбэрийн хандив өгөхийг хатуу хориглодог. | 2 | |
| ДҮН | | | | 6 | 100% |
| ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ | | | | | |
| Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана | | | | | |
| 32 | <i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт,</i> | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банкны www.golomtbank.com цахим хуудас нь монгол англи хэл дээр идэвхтэй ажилладаг ба үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллүүд, жилийн үйл ажиллагааны тайлан, тогтвортой хөгжлийн | 2 | |

| | | | | | |
|----|--|--------------------|---|---|--|
| | <i>гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i> | | тайлан, засаглалын зохион байгуулалт, санхүүгийн байдлын талаарх тайланг жилээр болон улирлаар тайлагнан ажилладаг ба бүтээгдэхүүн болон цаг үеийн мэдээллийг шуурхай тухай бүр хүргэхийг зорьдог. Голомт банкны ХЭХ-ийн бүтэц, эзэмшлийн хувь хэмжээ, ТУЗ-ийн гишүүд, тэдгээрийн хороодын мэдээлэл, Голомт банкны бүтэц зураглал зэрэг засаглалтай холбоотой мэдээллүүдийг тогтмол шинэчилж цахим хуудаснаа байршуулж ажилладаг. | | |
| 33 | 9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь тайлант хугацаанд хувьцаа эзэмшигч нартай харилцах тогтолцоог хууль журмын дагуу бий болгосон ба жил бүрийн сүүлээр дараагийн жилийн ажлын төлөвлөгөө, ээлжит хурлын товуудыг гаргаж оролцогч талуудад мэдээллийг хүргүүлж ажилладаг. Үүний дагуу ямар мэдээлэл хэзээ гаргах, хүргэгдэх зэрэг харилцаа төлөвлөгөө хөтөлбөр байдлаар гарч хэрэгжүүлдэг. Голомт банк нь 2022 оны 11-р сараас албан ёсоор ХК болсонтой холбоотой хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим хаягийг нээж ажиллаж байна, үүн дээр нэмээд цахим сувгийг хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 2 | |
| 34 | 9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ. | Бүрэн хэрэгжүүлсэн | Голомт банк нь хувьцаат компани болсноос хойш анх удаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023.02.02-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хурлын танхимд зохион байгуулсан. Хурлыг зохион байгуулахдаа Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Голомт банкны "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам"-ын дагуу төлөвлөгөө гарган ажилласан. Хурлын тайлан мэдээг СЗХ, МХБ, МБ руу хуулийн хугацаанд илгээсэн ба хурал зохион байгуулалттай холбоотой аливаа алдаа, зөрчил гараагүй болно. Хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцох, санал өгөх, асуулт асуух эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлөөр хангах үүднээс хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, урьдчилан санал авах цахим системийг хөгжүүлсэн ба үүгээрээ дамжуулан санал өгөх зааварчилгаа, хурлын материалыг байршуулан мэдээлэл авах боломжоор ханган ажилласан. Хуралтай холбоотой аливаа асуулт, саналыг и-мэйлээр болон лавлах утсаар нээлттэй хүлээн авч, шийдвэрлэн ажилласан. | 2 | |
| 35 | 9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа | Бүрэн хэрэгжсэн | Голомт банк нь хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд оролцох, санал өгөх аливаа эрхээ хэрэгжүүлэхэд нь анхаарч тус асуудлыг чухалчилан үздэг. Тайлант 2022 онд Олон | 2 | |

| | | | | | |
|--------------------|--|--------------|---|-----------|-------------|
| | <i>эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i> | | нийтэд хувьцааг нээлттэй худалдаалах үйл ажиллагаатай холбоотой шинээр гаргаж буй хувьцаа, түүний үнэ, нээлттэй арилжаалах төлөвлөгөө зэрэг асуудлыг ХЭХ-д тухай бүр бүрэн танилцуулж ажилласан байна. Мөн альваа шинэ хөрөнгө оруулалт татах, аль нэг хувьцаа эзэмшигчээс хөрөнгө оруулах тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчдэд бүрэн танилцуулж, тэргүүн ээлжинд худалдан авах эсэхийг лавлаж, бичгээр баталгаажуулж ирсэн. | | |
| 36 | 9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ. | Хэрэгжүүлсэн | Голомт банк нь сонирхлын зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай гэрээ хэлцэлийн чанараас хамаарч тус бүрийн журам (Зээлийн хорооны дүрэм)-д тусгаж зохицуулсан байна. Харин банкны нэгдсэн байдлаар мөрдөх Сонирхлын зөрчлөөс сэргийлэх бодлогыг Банкны Засаглалын код-ын хэсэг болгон тунхагласан. Мөн "Сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх журам"-ыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байна. Мөн ТУЗ-ийн хэмжээн Аудитын хороогоор сонирхлын зөрчилтэй хэлцэлийг хянах, батлах, ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороогоор сонирхлын зөрчилтэй зээлийг хянах/батлах асуудлыг тусган зохицуулсан байна. Сонирхлын зөрчилтэй хэлцэлийг хэрхэн батлахад чиглэсэн бодлого журмын дагуу шийдвэрүүд гарсан эсэхийг Дотоод аудитын газраас баталгаажуулж тогтмол тайлагнадаг. Харин хөндлөнгийн аудитын байгууллагаас жилийн үйл ажиллагааг шалгахад нийт хэлцэлүүдийг хянаж, зохистой хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг баталгаажуулан дүгнэлтийг гаргадаг ба энэхүү мэдээллийг жилийн тайланд тусгаж олон нийтэд нээлттэй болгодог. | 2 | |
| ДҮН | | | | 10 | 100% |
| НЭГДСЭН ДҮН | | | | 72 | 100% |

Дүгнэлт

“Голомт банк” ХК нь Монголын Хөрөнгийн Биржээс баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу нийт 9 бүлэг бүхий 36 асуулгаар, анх удаа өөрийн компанийн үнэлгээг гүйцэтгэлээ. Голомт банк нь 2022 оны 11 дүгээр сард албан ёсоор хувьцаат компани болсонтой холбоотой үнэлгээг гүйцэтгэхдээ хамрах хугацааг 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 5 дугаар сар хүртэл тооцсон болно.

“Голомт банк” ХК-ийн үнэлгээний нийт оноо 72 үнэлгээний хувь 100% буюу засаглал хэвийн эрсдэлгүй байна. Хувьцаат компани болсонтой холбоотой засаглал, мэдээллийн нээлттэй ил тод байдал, хувьцаа эзэшигч, олон нийтэд хүргэх ёстой тайлан, мэдээ мэдээллийг шинэчлэх, сайжруулах шаардлагатай болсон бөгөөд энэхүү үнэлгээг гүйцэтгэснээр бидний анхаарал хандуулан ажиллах ёстой ажлуудыг улам нарийвчлан гаргаж өгч буй нь их хэрэгцээтэй байна.

Үнэлгээний үр дүнд “Голомт банк” ХК нь компанийн засаглалыг сайжруулах хүрээнд 2023 онд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Засаглалын баримт бичигтэй холбоотойгоор:
 - Засаглалын кодексыг шинэчлэх,
 - ТУЗ-ийн ажлын албаны журмыг шинээр боловсруулах,
 - Хувьцаа эзэмшигчтэй харилцах журам шинээр боловсруулах,
 - Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг шинээр боловсруулах.
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаатай холбоотойгоор:
 - Цалин урамшууллын хороог тусад нь салгаж, холбогдох дүрмийг шинэчлэн батлах,
 - Нэр дэвшүүлэх хороог тусад нь салгаж, холбогдох дүрмийг шинэчлэн батлах.
3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан сайжруулалттай холбоотойгоор дараах агуулгыг нэмэх:
 - ТУЗ-ийн ажлын тайлан,
 - ТУЗ-ийн хуралдсан байдал, гишүүдийн ирц,
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын мэдээлэл,
 - Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан.
4. Мэдээллийн нээлттэй ил тод байдлын хүрээнд:
 - www.golomtbank.mn цахим хуудсанд “Хувьцаа эзэмшигчдэд” зориулсан буланг үүсгэх, агуулга, мэдээллийг сайжруулах,
 - Компанийн засаглалтай холбоотой баримт бичиг, дүрэм журмыг цахим хуудсаар нийтлэх.

Тайланг хянасан:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго

Бэлтгэсэн:

ТУЗ-ийн ажлын алба, менежер Б.Нарантуяа

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН”

Нотлох баримт бичгийн жагсаалт:

1. Голомт банк - Засаглалын кодекс
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
4. ТУЗ-Аудитын хорооны дүрэм
5. ТУЗ-Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэм
6. ТУЗ-Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дүрэм
7. Эрсдэлийн удирдлагын газрын дүрэм
8. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо
9. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах дотоод журам
10. Компанийн бүтэц
11. Хүний нөөцийн бодлого
12. Цалин хөлсний журам
13. Ажилтанд нийгэм ахуйн хөнгөлөлт үзүүлэх, тэтгэмж олгох журам
14. Сургалт хөгжлийн журам
15. Салбар нэгжийн гүйцэтгэлийг үнэлэх журам
16. Төвийн нэгжийн гүйцэтгэлийг үнэлэх журам
17. Комплаенсийн бодлого
18. МУТСТ үйл ажиллагааны журам
19. Сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам
20. Шүгэл үлээх заавар
21. 2023.02.02 ХЭХ тайлан/хурлын тэмдэглэл
22. Голомт банк - Цахим хаяг <https://golombank.com/>
23. 2021 оны Жилийн тайлан
<https://golombank.com/wp-content/uploads/2022/08/Annual-Report-2021-mn.pdf>
24. 2021 оны Тогтвортой хөгжлийн тайлан
<https://golombank.com/about-bank/sustainable-development/sustainable-development>
25. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга (мэдлэг туршлага, ур чадвар)
<https://golombank.com/about-bank/management/board-of-directors>